

ХАСБАНК ХК ("ХАСБАНК" ЭСХҮЛ "БАНК")-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 29-НИЙ ӨДРИЙН ЛХАГВА ГАРАГИЙН 09:00-11:45 (УЛААНБААТАРЫН ЦАГААР) ЦАГИЙН ХООРОНД МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, ШАНГРИ-ЛА ЗОЧИД БУУДАЛ, ИХ ТАНХИМД ХУРАЛДСАН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ОГНОО БА ХУРАЛДСАН ГАЗАР

Банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал ("ХЭЭХ") 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Лхагва гарагийн 09.00-11:45 цагийн /Улаанбаатарын цагаар/ хооронд Монгол Улс, Улаанбаатар хот, Шангри-Ла зочид буудлын Их танхимд хуралдав. Хурал танхим болон цахим хосолсон байдлаар зохион байгуулагдав.

ХЭЭХ-ыг монгол хэлээр хөтлөн явуулж, илтгэлүүдийг мөн монгол хэлээр тавьсан бөгөөд хурлын дарга Санжай Гүптагийн англи хэл дээр илтгэсэн нээлтийн үг болон бусад яриаг орчуулагчийн тусламжтайгаар монгол хэл дээр шууд хөрвүүлэн хүргэв. Гадаад хөрөнгө оруулагч нарт мөн зориулж, синхрон орчуулгыг англи хэл дээр нэгэн зэрэг явуулав.

1. ХУРЛЫН НЭЭЛТ

Банкны Дүрмийн 8.9 дэх хэсэгт заасны дагуу ТУЗ-ийн дарга Санжай Гүпта ("Хурлын дарга") ХЭЭХ-ыг даргалав.

Хурлын дарга ХасБанк ХК-ийн ХЭЭХ-д оролцож буй нийт хувьцаа эзэмшигчдэдээ талархал илэрхийлээд нээлтийн үг хэлэв:

"Өглөөний мэнд, ХасБанкны ХЭЭХ-ын үйл ажиллагаанд тавтай морилно уу.

Одоогоос 25 жилийн өмнө бид бичил санхүүгийн байгууллага хэлбэрээр үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол өнөөдөр зах зээлийн үнэлгээ нь нэг их наяд төгрөг давсан цөөн хэдэн нээлттэй компаниудын нэг болоод байна. Энэхүү түүхэн 25 жилийн гайхалтай аялалд хамт байсан бүгдэд нь талархал илэрхийлье. Эдгээр жилүүдэд хувь нэмрээ оруулсан хүн бүр өнөөдөр энд цуглаагүй ч, энд хүрэлцэн ирсэн хүн бүр яах аргагүй банкны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан билээ. Та бүхэндээ маш их баярлалаа.

ХасБанк нь Монгол улсын банкны салбарт өвөрмөц байр суурьтай бөгөөд нэг ч хувьцаа эзэмшигч холбогдох этгээдийнхээ хамт банкны хувьцааны 20-с илүү хувийг эзэмшдэггүй. Хувьцаагаа олон нийтэд анх удаа санал болгох (IPO)-оос өмнө банкны 100%-ийг, IPO-ийн дараа 95%-ийг эзэмшиж байсан Тэнгэр Санхүүгийн Нэгдэл (ТСН) нь 2025 онд Банктай нэгдсэн. Үүний үр дүнд ТСН-ийн хувьцаа эзэмшигчид одоо ХасБанкны шууд хувьцаа эзэмшигчид болсон.

Та бүхний мэдэхээр ХасБанк нь хоорондоо харилцан хамааралгүй 7 нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон олон тооны жижиг хувьцаа эзэмшигчидтэй.

Ямар нэгэн хувь хүн, гэр бүл эсвэл тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн хяналтад байдаггүй энэхүү онцгой байр суурь маань манай засаглалыг бэхжүүлж, мэргэжлийн удирдлагаар хангах нөхцөлийг бүрдүүлдэг ба энэ нь бүх оролцогч талуудад үр өгөөжөө өгч байна гэдэгт би итгэлтэй байна.

Холбогдох этгээдийн зээлийн хэмжээ Монгол улсад хамгийн бага байгаа нь манай өмчлөлийн бүтэц, Төлөөлөн удирдах зөвлөл болон удирдлагын багийн Банкаа хамгаалах зорилготой энэхүү чухал асуудалд баримталж буй тууштай бодлогын үр дүн юм.

2025 онд банкны салбар дэлхийн болон дотоодын маш хүчтэй сорилтуудтай нүүр тулсан. Би өнгөрсөн жилийн ХЭЭХ-ын үеэр энэ талаар товч дурдаж байсан ч харамсалтай нь бодит байдал бидний төсөөлж байснаас илүү хүнд байлаа.

2025 онд тулгарсан эдгээр сорилтуудын ихэнх нь одоо ч хэвээр байгаа, мөн Ойрх Дорнодын дайн мэт шинэ сорилтууд нэмэгдсэн ба геополитикийн хурцадмал байдал,



цочрол нь дэлхийн эдийн засгийн тогтолцоонд дахин хохирол учруулж байна. Энэхүү тодорхойгүй орчинд бид бизнесээ удирдахдаа маш сонор соргог, уян хатан байх шаардлагатай.

2025 онд манай удирдлагын баг эдгээр сорилтуудыг үл харгалзан банкны үйл ажиллагааг амжилттай удирдаж чадсан. Хэдийгээр эдийн засгийн орчин хүнд байсан ч IPO хийх үеийн 2025 онд хүрнэ гэж төлөвлөж байсан хүлээлтээс давсан үзүүлэлттэй гарлаа.

Жилд хоёр удаа ногдол ашиг тогтмол хуваарилж ирсэн хэдий ч манай нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ 20 хувьтай байгаа нь салбартаа хамгийн шилдэг үзүүлэлт болоод байна. Үүний зэрэгцээ бид хөрвөх чадвараа өндөр түвшинд тогтвортой хадгалж чадсан. Өөрийн хөрөнгө болон хөрвөх чадвар сайн байгаа хэр нь манай өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) 21.8 хувьд хүрсэн нь үнэхээр бахархмаар амжилт бөгөөд манай чанаргүй зээлийн харьцаа салбартаа хамгийн бага түвшинд байгааг дуулгахад таатай байна. Түүнчлэн бид зардлаа сайн хянаж ажилласны үр дүнд зардал орлогын харьцаа маань долоон жилийн өмнөх үзүүлэлттэй харьцуулахад хоёр дахин буурсан үзүүлэлттэй гарлаа.

Эдгээр сорилттой цаг үед ч харилцагч болон нийгэмд үйлчлэхэд анхаарлаа бүрэн хандуулж чадсан нийт ажилтнуудаараа би маш их бахархаж байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурал учраас хувьцаа эзэмшигчдийн өгөөжийн талаар товч дурдах нь зүйтэй байх. Бид банкны үйл ажиллагааг өдөр тутмын хувьцааны ханшид санаа зовж явуулдаггүй ба урт хугацаандаа бидний хичээл зүтгэл, хувь нэмэр хувьцааны үнэд тусгалаа олно гэдэгт итгэж байна.

Би та бүхэнтэй хоёр томоохон ололт амжилтаасаа хуваалцахыг хүсэж байна.

Хувьцааны ханш байнга хэлбэлзэж байдаг тул би энэхүү илтгэлийг бэлтгэж байх үеийн мэдээллийг танилцуулъя. Аль өдөр гэдгээс хамааран хувьцааны тоон үзүүлэлтүүд бага зэрэг зөрүүтэй байж болох талтай. IPO гаргаснаас хойш бараг 3 жилийн хугацаанд хувьцааны ханшийн өсөлтөөр дамжуулан 59 орчим хувь, ногдол ашиг хэлбэрээр дахин 19 орчим хувийн өгөөж авчирсан байна. Энэ нь IPO гаргаснаас хойш хувьцаа эзэмшигчийн нийт өгөөж ойролцоогоор 78 хувьд хүрсэн гэсэн үг юм.

Мөн та бүхний мэдэж байгаачлан бид ногдол ашгийг цэвэр ашгаасаа хуваарилдаг. Үлдэх ашиг нь банкны цэвэр хөрөнгийг нэмэгдүүлэх буюу банкны балансын үнийг өсгөхөд зарцуулагддаг. Хоёр дахь сонирхолтой баримтыг хуваалцахад, сүүлийн гурван жилийн хугацаан дахь манай нийт цэвэр ашиг IPO гарахын өмнөх банкны балансын үнэтэй бараг тэнцэж байна. Өөрөөр хэлбэл ногдол ашгийг оруулаад тооцвол бид ердөө гурван жил хүрэхгүй хугацаанд банкны балансын үнэлгээг бараг хоёр дахин нэмэгдүүлэх байсан гэсэн үг юм. Та бүхний мэдэхээр энэ төрлийн амжилт гарааны болон хөгжлийнхөө эхэн үед яваа компаниудад түгээмэл байдаг ч 25 жилийн түүхтэй банк мэт уламжлалт салбарын хувьд тун ховор үзэгдэл билээ.

Банкны салбар бол багийн тоглолт бөгөөд ийм онцгой амжилтад зөвхөн бид бүгд нэг баг болж ажилласнаар л хүрч чадна. Эдгээр онцгой ололт амжилтыг бүтээлцсэн хувьцаа эзэмшигчид, Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүд, удирдлагын баг болон нийт ажилтнууддаа талархал илэрхийлье.

Одоо ТУЗ-өөс чөлөөлөгдөж буй гишүүдийн талаар цөөн үг хэлье. Өнгөрсөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгогдсон дөрвөн ТУЗ-ийн гишүүн энэ удаагийн санал хураалтаар дахин нэр дэвшээгүй байгаа.

Тэдний гурав нь нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшсэн бөгөөд хувьцаа эзэмшигчид нь энэ удаад өөр шийдвэр гаргасан байна. ТУЗ-ийн гишүүд болох Албертус Брагинк, Анджей Витак болон Доминик Жак нарт ТУЗ-ийн үйл ажиллагаанд үнэ цэнтэй хувь нэмэр оруулсанд нь талархал илэрхийлье. Тэдэнтэй хамт ТУЗ-д ажилласан нь нэр төрийн хэрэг байлаа.



Дөрөв дэх гишүүн нь 2015 оноос хойш ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажилласан Б.Уламбаяр юм. Уламбаяр гишүүн олон жилийн турш ТУЗ-д нэр төртэй, тууштай зүтгэж ирсэнд нь талархаж байна. Нэр дэвшүүлэх хорооноос түүнийг анх дахин нэр дэвшүүлэхээр сонгосон байсан ч хувийн шалтгаанаар эцсийн мөчид нэрээ татсан гэдгийг нэмж хэлмээр байна. Түүнийг ирээдүйд хэзээ нэгэн цагт ТУЗ-д эргэн ирэх боломж бүрдэнэ гэдэгт мөн найдаж байна. Уламбаяртай ТУЗ-д хамтран ажилласан нь нэр төрийн хэрэг байлаа.

Ажлаас чөлөөлөгдөж буй дөрвөн гишүүддээ сайн сайхан бүхнийг хүсье.

Өнөөдөр дэлхий даяар макро эдийн засаг болон улс төрийн олон сорилттой тулгарч байгаа бөгөөд цаашид ч амаргүй байх болох ч би ХасБанкны ирээдүйг маш өөдрөгөөр харж байна.

ХасБанкны хувьд бид туулах замд тулгарах сорилтуудаас хамааран өгсөх хурдаа өөрчилж болох ч, оргилд нь заавал хүрэх болно.

Баярлалаа.”

2. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ИРЦ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийн дагуу, ХЭЭХ-д энгийн олонх оролцсоноор буюу Банкны нийт саналын эрх бүхий хувьцааны 50%+1 хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид биечлэн эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцсоноор хурал хүчин төгөлдөр болохыг тэмдэглэв.

Тооллогын комиссын дарга, Кэй И Партнерс ХХН-ийн Гишүүн Б.Ананд, Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)–ийн 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн R-2026-21 дүгээр тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарласныг дурдаад, ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн хуралд ашиглаж буй ХасМийтинг (ХасMeeting) аппликейшнд хөндлөнгийн аудитыг Проактив сольшнс ХХК хийсэн ба системийн ердийн болон кумулятив санал хураалтын процесс нь хувьцаа эзэмшигчдийн саналыг оролтын мэдээлэлд суурилан үнэн зөв тооцоолж, гаралтыг бодитойгоор тайлагнадаг болохыг 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр баталгаажуулсан гэж тэмдэглэв.

Тооллогын комиссын дарга Банкны зарласан нийт 1,052,700,000 (нэг тэрбум тавин хоёр сая долоон зуун мянга) ширхэг энгийн хувьцаанаас бүртгэлийн өдөр болох 04 дүгээр сарын 14-ний өдрийн байдлаар Банкны хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийн хүрээнд халаасалсан 2,853,223 (хоёр сая найман зуун тавин гурван мянга хоёр зуун хорин гурав) ширхэг энгийн хувьцааг Компанийн тухай хуулийн дагуу Тооллогын комисс саналын эрхгүй гэж тогтоосон болохыг зарлав. Ийнхүү ердийн журмаар шийдвэрлэх асуудал тус бүрээр саналын эрхтэй нийт хувьцааны тоо 1,049,846,777 (нэг тэрбум дөчин есөн сая найман зуун дөчин зургаан мянга долоон зуун далан долоо) ширхэг энгийн хувьцаа бөгөөд тус хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдээс 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ХЭЭХ-д 1,011,148,573 (нэг тэрбум арван нэгэн сая нэг зуун дөчин найман мянга таван зуун далан гурав) ширхэг энгийн хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцсон тул хурлын ирц 96.3%-иар бүрдсэнийг зарлав.

Ийнхүү, Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийн дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц бүрдэж, хурал хүчин төгөлдөр болсныг мэдэгдэв.

ХЭЭХ-д дараах бусад оролцогчид оролцов:

	ТУЗ-ийн гишүүд	
1	Санжай Гүпта	ХасБанкны ТУЗ-ийн дарга
2	Г.Цэвэгжав	ХасБанкны Гүйцэтгэх захирал ба ТУЗ-ийн гишүүн (“Гүйцэтгэх захирал”)
3	Б.Уламбаяр	ХасБанкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн
4	Нираж Вадва	ХасБанкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн



5	Эми Чой	ХасБанкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн
6	Стюарт Холл	ХасБанкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн
7	Н.Цэлмүүн	ХасБанкны ТУЗ-ийн гишүүн
8	Майкл Мадден	ХасБанкны ТУЗ-ийн гишүүн
9	Сюзанна Карр	ХасБанкны ТУЗ-ийн гишүүн
Гүйцэтгэх удирдлага		
1	Г.Эрдэнэбаяр	ХасБанкны Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч бөгөөд Иргэдийн банк хариуцсан захирал
2	Б.Еркин	ХасБанкны Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Байгууллагын банк хариуцсан захирал
3	С. Дауренбек	ХасБанкны Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Бизнесийн банк хариуцсан захирал
4	Д.Мөнхзул	ХасБанкны Лизинг хариуцсан захирал
5	Г.Тамир	ХасБанкны Санхүү хариуцсан захирал
6	Илиа Аврамов	ХасБанкны Эрсдэл хариуцсан захирал
7	Э.Ундармаа	ХасБанкны Зээл хариуцсан захирал
8	Г.Зул	ХасБанкны Хүний нөөц, захиргаа хариуцсан захирал
9	Э.Уламбаяр	ХасБанкны Үйл ажиллагаа хариуцсан захирал
10	Х.Өнөрбат	ХасБанкны Мэдээллийн технологи хариуцсан захирал
11	Н.Мөнхцэлмэг	ХасБанкны Хууль хариуцсан захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга ("ХХЗ/ТУЗНБД")
Гүйцэтгэх удирдлагын бус оролцогч		
1	Б.Биндэрьяа	ХЭЭХ Зохион байгуулах комиссын дарга, ХасБанкны Ерөнхий аудитор
Тооллогын комисс		
1	Б.Ананд	Кэй И Партнерс ХХН-ийн Гишүүн
2	М.Лхамсүрэн	Кэй И Партнерс ХХН-ийн Гишүүн
3	Г.Хажидмаа	Кэй И Партнерс ХХН-ийн Эрх зүйч

ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүд болох Б.Уламбаяр, Нираж Вэдва, Эми Чой болон Стюарт Холл нар нь хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулахаар биечлэн ХЭЭХ-д оролцов.

3. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжав ХасБанкны ХЭЭХ-д хүрэлцэн ирсэн хүн бүрийг халуун дотноор угтан авч талархлаа илэрхийлээд, хувьцаа эзэмшигчдэд ХЭЭХ-ын дэгийг танилцуулав.

4. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

Гүйцэтгэх захирал ХЭЭХ-ын хэлэлцэх асуудлыг ТУЗ-өөс баталж, нийт хувьцаа эзэмшигчдэд зохих журмын дагуу урьдчилан мэдээлсэн гэдгийг дурдав.

Хурлын хэлэлцэх асуудлыг хувьцаа эзэмшигчдэд дараах байдлаар танилцуулав:

Танилцуулах асуудал:

1. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тайлан.

Шийдвэрлэх асуудал:

1. ХасБанкны 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай;
2. ХасБанкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай;



3. ХасБанкны 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай;
4. Хувьцаа эзэмшигчдийн 2028 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай;
5. ТУЗ-ийн 2026 оны төсвийг батлах тухай.

Үргэлжлүүлэн тэрээр, хөндлөнгийн Тооллогын комиссын бүрэлдэхүүн болоод ХасМийтинг (ХасMeeting) аппликейшнийг ашиглан санал өгөх зааврыг товч танилцуулав. Үүнд, ердийн журмаар шийдвэрлэх асуудалд зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн сонголтуудаас сонгох бол, кумулятив аргаар шийдвэрлэх ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудалд өөрийн эзэмшиж буй хувьцааны тоог ТУЗ-ийн нийт гишүүдийн тоо болох 12-оор үржүүлж санал өгөх тухай тайлбарлав.

Танилцуулгын дараагаар, хурлын дэг болон хэлэлцэх асуудалд холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт буй эсэх талаар Гүйцэтгэх захирал тодруулав. Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асуугаагүй болно.

5. ХАСБАНКНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

- Үйл ажиллагааны онцлох үйл явдал

Гүйцэтгэх захирал Банк тайлант хугацаанд залуу бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкнаас 147 сая ам.долларын эх үүсвэрийг татан төвлөрүүлж, зах зээлд шинэ бүтээгдэхүүн болох Залуу бизнес эрхлэгчид зориулсан зээлийг нэвтрүүлсэн, БЖДБ эрхлэгчид, тэр дундаа залуу болон эмэгтэй бизнес эрхлэгчид болоод ногоон бизнесийг дэмжих зорилгоор Нидерландын Хөгжлийн Банкнаас 150 сая ам.долларын санхүүжилт татах гэрээ байгуулсан болохыг тэмдэглэв. Мөн ХасБанк нь 2025 оны “Онцлох ToC Банк”-аар дахин шалгарсан бөгөөд Global Finance сэтгүүлээс Банкныг Монгол Улсын шилдэг банкаар шалгаруулсан талаар үйл ажиллагааны онцлох үйл явдлуудыг танилцуулав.

Түүнчлэн ХасБанкны толгой компани ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх ажиллагаа зохицуулагч байгууллагуудын зөвшөөрөл ёсоор 2025 оны 08 дугаар сард бүрэн дуусгавар болж, ХасБанк Банкны тухай хуулийн 36.1 дэх хэсэгт заасан нэг хувьцаа эзэмшигч дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувьцааны төвлөрөл 20%-иас хэтрэхгүй байх шаардлагыг хуулийн хугацаанаас даруй нэг жил гаруйн өмнө хангасан системийн хэмжээний анхны банк болсон талаар онцлон тэмдэглэв.

Тэрээр Fitch Ratings агентлагаас Банкны зээлжих зэрэглэлийг “В+ тогтвортой” төлөвтэй хэвээр баталгаажуулсан бол, Moody’s агентлагаас Монгол Улсын зээлжих зэрэглэл сайжирсан болон Банкны санхүүгийн үзүүлэлт тогтвортой сайжирсныг харгалзан ХасБанкны зээлжих зэрэглэлийг “В1/тогтвортой” болгон нэг шат ахиулан сайжруулсан талаар дурдав. Үүний үр дүнд гадаад эх үүсвэрийн зардал буурах ач холбогдолтой болно.

Мөн Instaxpay цахим хэтэвч, ХасTeen+ хүүхэд залууст зориулсан апп, Ebarimt хялбар бүртгэл, Iban лавлах үйлчилгээ, ХасTeen карт, UnionPay картыг Alipay болон Wechat апп-д шууд холбох төлбөр тооцооны шийдэл зэрэг тайлант хугацаанд нэвтрүүлсэн шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийн талаар танилцуулав.

- Санхүүгийн үзүүлэлт

Гүйцэтгэх захирал 2025 оны санхүүгийн гол үзүүлэлтүүдийг онцлон танилцуулав. Үүнээс, цэвэр ашиг 172.6 тэрбум төгрөг болсон нь өмнөх оны 171.7 тэрбум төгрөгийн цэвэр ашгаас 0.5%-ийн өсөлттэй дүн бөгөөд үүнд макро эдийн засгийн хүндрэлт нөхцөл байдал,



дотоод, гадаад үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлагын хүрээнд хийсэн зээлийн багцын өсөлтийн хязгаарлалт зэрэг хэд хэдэн хүчин зүйлс нөлөөлсөн. Түүнчлэн, салбарын чанаргүй зээлийн асуудал хүндэрсэнтэй холбогдуулан чанаргүй зээлийн сан байгуулсан, зохицуулагч байгууллагуудын бодлогод оруулсан өөрчлөлт буюу свопын зардал нэмэгдсэн, банкуудын заавал байлгах нөөцийн хэмжээг шат дараатай нэмсэн, тус нөөцөд хүү тооцохоо больсон. Үүнээс үүдэн, Банкны татварын дараах цэвэр ашигт ойролцоогоор 29 тэрбум төгрөгөөр нөлөөлсөн болохыг тайлбарлав.

Гүйцэтгэх захирал үргэлжлүүлэн санхүүгийн өөр бусад үзүүлэлтүүд болох өөрийн хөрөнгийн өгөөж (ROE), төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний тоон үзүүлэлтүүдийн талаар танилцуулав. Тэрээр Банкны гол стратегийн хүрээнд санхүүгийн нийт үзүүлэлтүүдийн тогтвортой өсөлтийг жил тутам хадгалахыг зорьдог талаар тайлбарлав.

Тэрээр Банкны нийт зээл болон санхүүгийн түрээсийн багц 13.1% өссөнтэй зэрэгцээд активын чанараа сайн хэвээр хадгалан ажилласны үр дүнд нийт багцад эзлэх чанаргүй зээлийн харьцаа үзүүлэлтийг салбартаа хамгийн доод түвшинд буюу 2.5%-д хадгалан ажилласан болохыг онцлон тэмдэглэв.

Банкны зээлийн үйл ажиллагаа нь Иргэдийн банк (ойролцоогоор нийт зээлийн багцын 65%-ийг эзэлдэг), Байгууллагын банк болон Хаслизинг (Санхүүгийн түрээс) гэсэн үндсэн гурван бизнесийн сегментэд хуваагддаг бөгөөд тэдгээрийн зээлийн багцын өсөлтийн талаар товч танилцуулав.

Гүйцэтгэх захирал үргэлжлүүлэн харилцах, хадгаламж (дотоод эх үүсвэр), гадаад эх үүсвэрийн талаарх голлох үзүүлэлтүүдийг онцлон Банкны санхүүгийн үзүүлэлтүүд тогтвортой байгааг тэмдэглэв. Тэрээр мөн Банк эх үүсвэрийн удирдлагын хүрээнд дотоод болон гадаад эх үүсвэрийг тэнцвэртэйгээр татан төвлөрүүлдэг болохыг тайлбарлав.

- **Хувьцааны мэдээлэл**

Гүйцэтгэх захирал Банкны хувьцааны мэдээллийг товч танилцуулав. 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр буюу оны сүүлчийн арилжааны өдөр Банкны хувьцааны хаалтын ханш 963.9 төгрөгт хүрч, өмнөх оны хаалтын ханш болох 826.0 төгрөгөөс 16.7%-иар өссөн амжилттай үзүүлэлттэй байна. Хувьцааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, энэ хүрээнд баримтлах Банкны стратеги, 2026 оны төлөвлөгөөний талаар 2025 оны жилийн эцсийн буюу II хагас жилийн хуримтлагдсан ашгаас ногдол ашиг хуваарилах асуудлын танилцуулгаар дэлгэрүүлэх болно.

- **Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлт**

Гүйцэтгэх захирал Банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлтийн хүрээнд дараах гурван үзүүлэлтийг тоймлон хүргэв:

Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт: Монголбанкнаас банкуудад нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа үзүүлэлтийн доод хязгаарыг 9%-иар тогтоосон байдаг. Мөн системийн нөлөө бүхий банкуудад нөөц интервалын шаардлага 3.5% нэмж тогтоодог. ХасБанк нь нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа үзүүлэлтээ 2025 оны тайлант хугацаанд 20.1% буюу байвал зохих хэмжээнээс 7.6 нэгж хувиар давуулан хангаж ажилласан. Ийнхүү тус үзүүлэлтийг давуулан хангаж буй нь ХасБанкны аливаа болзошгүй эрсдэлийг хүлээх чадвар тэр хэмжээгээр ахиу болох, ирээдүйн зээлийн өсөлтийг хангах болон ногдол ашиг хуваарилах боломжтой буюу үйл ажиллагаагаа цааш тогтвортой эрхлэн удирдах чадвартай болохыг илтгэнэ.



Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлт: Монголбанкнаас арилжааны банкуудад төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлтийн доод хэмжээг 25%-иар тогтоосон байдаг. ХасБанк нь өөрийн эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд түргэн борлогдох актив хөрөнгийг бэлэн мөнгө эсхүл хамгийн бага эрсдэлтэйд тооцогдох хэрэгсэлд байршуулан удирдаж байгаа бөгөөд 2025 оны байдлаар тус харьцаа үзүүлэлтийг 37.6%-д хадгалан ажилласан.

Бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд: Гүйцэтгэх захирал Монголбанкнаас тогтоосон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг Банк хангаж ажилласныг онцлов.

- **Банкны засаглалын тайлан**

Гүйцэтгэх захирал цааш нь засаглалын тайланг танилцуулж, түүний хүрээнд 2024 оны ХЭЭХ-аар хууль тогтоомжийн дагуу сонгогдсон ТУЗ-ийн бүрэлдэхүүн болон тэдний ажлын тайланг товч танилцуулав. Мөн ТУЗ болон түүний дэргэдэх хороодын тайлант хугацаанд хуралдсан хуралдаан болоод ТУЗ-өөс гаргасан шийдвэр, баталсан дотоод засаглалын бодлого, журмууд болоод сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар товч танилцуулав.

- **Сангаас хаасан зээлийн тайлан**

Гүйцэтгэх захирал 2025 оны 11 дүгээр сарын ТУЗ-ийн хурлаар сангаас хаах зээлийн саналыг хэлэлцэн шийдвэрлэсэн талаар хувьцаа эзэмшигчдэд тайлбарлаж, тухайн сангаас хаасан зээлүүд нь Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайдын хамтарсан тушаалаар баталсан Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмын шаардлагыг бүрэн хангасан болохыг тэмдэглэв. Мөн Банк нь зээлийг сангаас хаасан эсэхээс үл хамаарч өр төлүүлэх ажиллагааг хэвийн үргэлжлүүлж ажиллаж байна.

Тэрээр сангаас хаасан зээлийг бүтээгдэхүүнээр ангилан танилцуулж, цалингийн, бичил бизнесийн, бусад хэрэглээний зээлийн бүтээгдэхүүнд нийт 916 сая төгрөгийн үнийн дүн бүхий 80 зээлийг сангаас хаасан болохыг тэмдэглэв.

Ийнхүү ХасБанкны ТУЗ нь Банкны 2025 оны үйл ажиллагааны тайланг сайтар хянан үзсэний үндсэнд, тус тайлан нь ХасБанкны үйл ажиллагааны үр дүнг бодитоор ил тод илэрхийлсэн гэж 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн R-2026-17 дугаар тогтоолоороо дүгнэсэн болохыг тэмдэглэв.

Гүйцэтгэх захирал Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалтын дагуу Банкны 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлахыг хувьцаа эзэмшигчдээс хүсэв.

Танилцуулгын дараагаар Гүйцэтгэх захирлын сануулснаар, хурлын дэгийн дагуу, хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асууж, хариулт авах цаг эхлэв.

ХЭЭХ-д биечлэн оролцож буй хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асуугаагүй тул, хуралд цахимаар оролцож буй хувьцаа эзэмшигчдийн тухайн хэлэлцэж буй асуудалд холбогдуулан асуусан дараах асуултыг Гүйцэтгэх захирал танилцуулав:

1. Өнгөрсөн жилийн ашиг орлогын өсөлт/бууралтын гол шалтгаан юу байсан талаар.

Гүйцэтгэх захирал тус асуултын хариуг танилцуулгын эхэнд маш дэлгэрэнгүй тайлбарласан тул ахин дурдах шаардлагагүй болов уу гээд, хэлэлцэх дараагийн асуудалд оров.

**6. ХАСБАНКНЫ 2025 ОНЫ АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ**

Гүйцэтгэх захирал Санхүү хариуцсан захирал Г.Тамирыг Банкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулахаар индэрт урив. Мөн тэрээр Эрснт энд Янг Монголия Аудит ХХК-ийн партнер Адриан Чу болон бусад мэргэжилтнүүд хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулахаар энэхүү хуралд хүрэлцэн ирснийг онцлов.

Санхүү хариуцсан захирал Г.Тамир нийт хувьцаа эзэмшигчдэдээ энэ өдрийн мэндийг хүргээд дараах танилцуулгыг хийв:

2025 онд дэлхийн 4 том аудитор байгууллагын нэг болох Эрснт энд Янг Монголия Аудит ХХК нь хуулийн дагуу ХасБанкны хараат бус аудиторoor сонгогдон ажилласан бөгөөд ХасБанкны санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандарт, дүрэм журмын дагуу хяналт хийж, удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь НББОУС болон СТОУС-ын дагуу материаллаг алдаагүй, бодитойгоор илэрхийлэгдсэн байна гэж дүгнэсэн.

Банкны тухай хуулийн дагуу ХасБанкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайланг дүгнэлтийн хамт хувьцаа эзэмшигчдэдээ болон олон нийтэд хуулийн хугацаандаа багтааж 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдөр бүрэн эхээр нь нээлттэй толилуулсан байгаа.

Аудитлагдсан тайлангийн 4-8 дахь хуудаст буй хараат бус аудиторын дүгнэлттэй хувьцаа эзэмшигчид та бүхэн танилцах боломжтой. Мөн аудитлагдсан тайлан нь санхүүгийн үндсэн дөрвөн тайлангаас гадна дэлгэрэнгүй 34 тодруулгатай, нийт 92 хуудас тайлан бөгөөд монгол болон англи хэлээр үйлдэж нийтэлсэн болно.

Компанийн тухай хуулийн дагуу ХасБанкны аудитлагдсан тайланг ТУЗ хэлэлцэж “ХасБанкны санхүүгийн байдлыг СТОУС болон НББОУС-ын дагуу бодитоор, ил тод тайлагнасан байна” гэж дүгнэсэн болохыг 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн ТУЗ-ийн R-2026-20 дугаар тогтоолоор баталгаажуулсан бөгөөд дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд ийнхүү танилцуулж байна гэв.

Санхүү хариуцсан захирал Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалтын дагуу Банкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталж шийдвэрлэхийг хувьцаа эзэмшигчдээс хүсэв.

Мөн тэрээр ТУЗ-ийн дүгнэлт болон аудитлагдсан санхүүгийн тайланд холбогдох хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулахад бэлэн буй талаар мэдэгдэв.

Хувьцаа эзэмшигчид асуулт асуугаагүй тул хэсэг хугацааны дараа хэлэлцэх дараагийн асуудалд оров.

7. ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙН ТАЙЛАН

Санхүү хариуцсан захирал ХасБанкны ТУЗ-ийн нийт хараат бус гишүүдийг төлөөлж тайланг танилцуулах ТУЗ-ийн хараат бус гишүүн Эми Чойг индэрт урив.

Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн Эми Чой ХЭЭХ-д оролцож буй хувьцаа эзэмшигчдэдээ талархал илэрхийлээд, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн нэрийн өмнөөс тайланг англи хэлээр танилцуулсныг орчуулагчийн тусламжтайгаар Монгол хэл дээр дараах байдлаар шууд хөрвүүлэв:

“Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, хамт олон, зочид оо,



Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн Та бүхэнд талархал илэрхийлье. Та бүхний ХасБанк дахь хөрөнгө оруулалтыг хамгаалах засаглалын тогтолцоо болон бидний хэрэгжүүлж буй үүрэг, хариуцлагын талаар тайлагнах боломж олдсонд бид баяртай байна.

1. Засаглалын хяналт

ТУЗ-ийн хараат бус гишүүдийн хувьд бидний үндсэн үүрэг нь Та бүхэнд буюу хувьцаа эзэмшигчдийн өмнө байгууллагын урт хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэдэг. Бид банкны үйл ажиллагаанд хараат бус, бодитой дүгнэлт хийж, гүйцэтгэх удирдлагын баг стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн шаардлагад нийцэж ажиллах, эрсдэлийн чиглэлээр сахилга баттай байх үүргээ биелүүлэн ажиллаж буй эсэхэд хяналт тавьдаг.

2025 онд ХасБанк нь байгууллагын бүтэц, засаглалын тогтолцоонд стратегийн ач холбогдол бүхий шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлж, аливаа этгээдийн дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших хувьцаа тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх Банкны тухай хуулийн шаардлагыг хангасан системийн нөлөө бүхий анхны банк болсон.

Мөн тус онд Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор засаглалын тогтолцоонд шинэчлэл хийж, байгууллагын дотоод зохион байгуулалтыг олон улсын шилдэг туршлагад нийцүүлэн шинэ түвшинд хүргэлээ. Үүнд:

- Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанктай амжилттай нэгтгэв.
- Санхүүгийн зохицуулах хорооны зөвлөмжийн дагуу Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороог хоёр тусдаа хороо болгон (Засаглал ба цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороо) хуваасан.
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрсдэлийн үнэлгээний шинэ аргачлалыг баталсан.
- Дотоод 17 бодлого, журмыг шинээр баталж, шинэчилсэн.
- банк болон жижиг хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох этгээдийн болон ашиг сонирхлын зөрчилтэй бүх хэлцлийг ТУЗ-өөр хянан хэлэлцэж баталсан.
- ТУЗ болон түүний хороод идэвхтэй ажиллаж, дараах байдлаар хуралдсан:

ТУЗ болон хороод	Нийт хурал	Онлайн санал хураалт	Баталсан тогтоол
ТУЗ	8	8	55
Эрсдэлийн удирдлагын хороо	5	19	-
Аудитын хороо	5	Байхгүй	-
Засаглал, цалин урамшууллын хороо	4	1	-
Нэр дэвшүүлэх хороо	3	Байхгүй	-

2. Стратегийн хэрэгжилт

- Стратегийн уялдаа: Банкны стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, харилцагчийн сэтгэл ханамж, үнэнч байдлыг нэмэгдүүлэх, ажилтнуудын бүтээмж, сэтгэл ханамжийг дэмжих, хөрөнгө оруулагчдад тогтвортой өгөөж бий болгох, технологи болон кибер аюулгүй байдалд тасралтгүй хөрөнгө оруулах, мөн харилцагчийг таньж мэдэх, мөнгө угаахтай тэмцэх болон зээлийн чанарын хяналтыг сайжруулахад анхаарч ажилласан.



- Гүйцэтгэлийн хяналт: Дэлхийн болон дотоодын эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд ч гүйцэтгэх захирал болон түүний багийн гаргасан санхүүгийн үр дүнг өндрөөр үнэлж байна.

Цэвэр ашиг:	172.6 тэрбум төгрөг (+0.5% өмнөх оноос)
Чанаргүй зээл:	2.5% (салбарын хамгийн бага түвшний нэг)
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө:	20.1% (доод шаардлага 12.5%)
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар:	37.6% (доод шаардлага 25%)
Зээлийн багцын өсөлт:	+13.1%
Харилцах/хадгаламжийн өсөлт:	+9.4%

2025 онд харилцагчид чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалт болон дижитал бүтээгдэхүүний нэвтрүүлэлтэд ахиц гарсан бөгөөд цаашид мөн сайжруулалтаа хяналттайгаар ахиулах шаардлагатай гэж үзэж байна.

Түүнчлэн, дижитал шилжилт, олон нийтийн сүлжээ болон спортын арга хэмжээг дэмжих зэргээр брэндийг таниулах, байрлуулах ажлыг үргэлжлүүлэн тогтмол хөрөнгө оруулалт хийснээр зах зээл дэх байр сууриа бэхжүүлж байгааг харахад таатай байна.

3. Эрсдэлийн удирдлага ба хянан нийцүүлэлт

- Зээлийн эрсдэл: бид активын чанар болон активын эрсдэлийн сангийн нөөц хангалттай эсэхийг хянаж ажиллав.
- Үйл ажиллагааны болон кибер аюулгүй байдлын эрсдэл: Дижитал орчинд банкны кибер аюулгүй байдлын тогтолцоог байнга сайжруулж буй эсэхэд хяналт тавьж байна.
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны эрсдэл: Санхүүгийн гэмт хэргийг үл тэвчих бодлогыг банк баримталдаг. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээрх банкны хяналтын тогтолцоо Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын стандарттай бүрэн нийцэж байна.

Банк эрсдэлийн хүлээн зөвшөөрөх зохих түвшингээ тодорхойлж түүнийгээ дагаж мөрддөгт бид сэтгэл хангалуун байна.

4. Аудит ба санхүүгийн үнэн зөв байдал

Бид дотоод аудитын нэгж болон хөндлөнгийн аудитортой нягт хамтран ажилласан. Жилийн санхүүгийн тайланг хянаж, банкны санхүүгийн байдал үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн гэж дүгнэсэн.

Мөн санхүүгийн болон санхүүгийн бус дотоод хяналтын тогтолцоо найдвартай байгаад сэтгэл хангалуун байна.

5. Дижитал ба мэдээллийн технологи

2025 онд ХасБанк харилцагчийг анх бүртгэхээс эхлэн хүрч үйлчлэх байдлыг сайжруулах, процессыг хялбаршуулах, онлайн автоматжуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр дижитал чадавхаа бэхжүүлсэн. Үүний хүрээнд, дижитал хэтэвчийг нэвтрүүлж төлбөрийн хялбар шийдлийг харилцагчиддаа санал болгож байна.

Нийцэл, эрсдэлийн удирдлага, засаглалын чиглэлээр мэдээллийн технологийн олон шинэ төслүүд хэрэгжүүлсэн. Мөн, кибер аюулгүй байдлын иж бүрэн аудитыг хөндлөнгийн байгууллагаар хийлгэж, мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог улам бэхжүүлэхээр ажиллаж байна.

**6. Дүгнэлт**

ТУЗ-ийн хараат бус гишүүдийн зүгээс ХасБанкийг засаглалын хувьд төлөвшсөн, санхүүгийн хувьд тогтвортой, урт хугацаанд тогтвортой өсөлт хийх боломжтой байгууллага гэж үзэж байна.

Гүйцэтгэх захирал болон түүний багт бидэнтэй хамтран ажилладагт тань, мөн хувьцаа эзэмшигч Та бүхэнд итгэл хүлээлгэн дэмжиж ирсэнд тань баярлалаа. Түүнчлэн ТУЗ-ийн даргын манлайлалд баяр хүргэж, биднийг өнөөгийн түвшинд хүргэж, ирээдүйн сорилтуудыг даван туулахад бэлтгэдэгт тань талархал илэрхийлье.

Баярлалаа!”

Тайланг танилцуулсны дараагаар Хурлын даргын зарласнаар хурлын дэгийн дагуу, хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асууж, хариулт авах цаг эхлэв.

Хувьцаа эзэмшигчид асуулт асуугаагүй тул хэсэг хугацааны дараа хэлэлцэх дараагийн асуудалд оров.

8. ХАСБАНКНЫ 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ЦЭВЭР АШГААС НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ

Хурлын дарга Банкны 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах талаар танилцуулахаар Гүйцэтгэх захирлыг дахин индэрт урив.

ХасБанкны нэгэн онцлог нь жилд 2 удаа ногдол ашиг тараах бодлогыг тогтмол хэрэгжүүлдэг бөгөөд энэ хүрээнд 2025 оны эхний хагас жилийн хуримтлагдсан ашгаас нэгж хувьцаанд 18.0 төгрөг буюу нийт 18.9 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хэлбэрээр тараан ажилласан. Энэ удаа ТУЗ-ийн зөвлөмж болгосны дагуу Банкны 2025 оны жилийн эцсийн буюу II хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хувьцаа эзэмшигчдэдээ зарлан хуваарилах тухай асуудлыг танилцуулахыг Гүйцэтгэх захирал тэмдэглэв.

Тэрээр үргэлжлүүлэн, Банкны стратегийн 3 тулгуур багана - Хөрөнгө оруулагч, Харилцагч болон Хасчууд -ын өмнө хүлээсэн итгэл, хүндлэлийг хадгалан хамгаалж ажиллахыг эрмэлздэг бөгөөд Банкны баримталж буй стратеги, 2026 оны үндсэн зорилт, 2025 оны цэвэр ашгийн зарцуулалтын талаар танилцуулав.

Мөн Монголбанкнаас ирүүлсэн шаардлагын дагуу 2027 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор өөрийн хөрөнгийн зохистой харьцааг 200 нэгж хувиар нэмэгдүүлэх буюу, одоогийн доод хэмжээ болох 12.5%-иас 14.5% болгож нэмэгдүүлэх шаардлага үүссэнийг Банк хөрөнгийн удирдлагыг зохистой хэрэгжүүлж ирсний хүчинд нэмэлт хөрөнгө татан төвлөрүүлэлгүйгээр дотооддоо зохион байгуулахаар төлөвлөж буйг тайлбарлав.

Хувьцааны өгөөжийн хувьд IPO-с хойш 04 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар 76.7%-ийн өсөлттэй ажилласан бөгөөд үүнд хувьцааны үнийн өсөлт 57.2%, ногдол ашгийн өгөөж 19.5%-тай байгааг тэмдэглээд, хувьцаа эзэмшигчдэдээ итгэл хүлээлгэсэнд дахин талархал илэрхийлэв.

Мөн 2025 онд ХасБанкны зах зээлийн үнэлгээ 1 их наяд төгрөгийг давснаар Монголын хөрөнгийн бирж дээрх нэг их наяд давсан үнэлгээ бүхий 6 компанийн нэг болсон. 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээгээр ТОП-20 индексийн комданиудын гуравдугаарт жагсаж байна.

Тэрээр Банкны Дүрэмд заасны дагуу энэхүү хувьцаа эзэмшигчдийн хурлаар ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж буйг тайлбарлав. Тус ТУЗ-ийн шийдвэрээр ногдол ашигт нэгж хувьцаанд 30.0 төгрөг буюу нийт 31.5 тэрбум төгрөгийг зарлан хуваарилахыг дэмжсэн байна.



Ингэснээр Банкны 2025 оны цэвэр ашгаас нийт 50.4 тэрбум төгрөгийг ногдол ашиг хэлбэрээр хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилж буй буюу Үнэт цаасны танилцуулгад тусгасан 2025 онд 49.5 тэрбум төгрөгийг ногдол ашигт тараах төсөөллийг давуулан биелүүллээ.

Мөн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр байхаар санал болгосон байна.

Түүнчлэн Гүйцэтгэх захирал нь хууль тогтоомжид нийцүүлэн ХасБанкнаас ногдол ашиг хуваарилах асуудлаар Монголбанкны зөвшөөрлийг авсан болохыг дурдав. Хэрэв хувьцаа эзэмшигчид ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд, СЗХ-ны зохицуулалтын дагуу 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор мөнгөн хөрөнгийг Үнэт цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК-д шилжүүлэх ба Үнэт цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК нь хувьцаа эзэмшигчдийн нэрийн дансанд байршуулахыг онцлов.

Танилцуулгын дараагаар Гүйцэтгэх захирлын сануулснаар, хурлын дэгийн дагуу, хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асууж, хариулт авах цаг эхлэв.

ХЭЭХ-д биечлэн оролцож буй хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асуугаагүй тул, хуралд цахимаар оролцож буй хувьцаа эзэмшигчдийн тухайн хэлэлцэж буй асуудалд холбогдуулан асуусан дараах асуултыг Гүйцэтгэх захирал танилцуулав:

1. Энэ жил ногдол ашиг тараах эсэх, тараах бол хэдэн хувиар тараах, ногдол ашгийн хувьд баримтлах урт хугацааны бодлогын талаар.
2. Хувьцааны ногдол ашгаас буцаан хувьцаа худалдан авах нөхцөлд ханшийн хөнгөлөлт үзүүлэх боломж бий эсэх. Жишээлбэл ХасБанкны ажилтанд ийм боломж бий эсэх.
3. Хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ногдол ашгийн хэмжээг нэмэгдүүлэх боломж бий эсэх.
4. Банк хувьцаагаа халаасалсан шалтгаан болоод ямар үед халаасны хугацааг зах зээлд эргүүлэн гаргахаар төлөвлөж буй талаар.

Гүйцэтгэх захирал дээрх асуултад дараах байдлаар хариулав:

1. Танилцуулгын хүрээнд нэгж хувьцаанд хэдэн төгрөгийг ногдол ашигт хуваарилах талаар танилцуулсан. Банкны ногдол ашгийн бодлогын хувьд, ирэх жилийн өсөлт, ерөнхий макро эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан ногдол ашигт хэдий хэмжээний хөрөнгө хуваарилах талаар ТУЗ тухайн жилийн ашигт ажиллагааг дүгнээд зөвлөмж гаргадаг. Банкны баримталж буй гол бодлого нь тухайн жилийн ашгийн тэдэн хувийг ногдол ашигт хуваарилна гэж тогтоохоос илүүтэй, нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээг хэрхэн аажим аажмаар нэмэгдүүлэхэд төвлөрдөг.
2. Эргүүлэн худалдан авсан хувьцааг хэрхэх асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлнэ. Өнөөдрийн байдлаар Банкны халаасалсан хувьцааны хэмжээ нь нийт гаргасан хувьцааны гагцхүү 0.2%-ийг эзэлж буй тул халаасны хувьцааг хэвээр нь хадгалж байна. Цаашдаа хэрхэх талаар асуудлыг тухайн цаг хугацаанд хувьцаа эзэмшигчдэдээ танилцуулж, шийдвэрлүүлэх болно. Хувьцааны үнэд хөнгөлөлт үзүүлэх асуудлын тухайд, өдгөө ХасБанкны 1,000 гаруй ажилтан маань Банкиндаа хөрөнгө оруулалт хийсэн байдаг. Хөрөнгө оруулагчид маань Банкны ажилтан эсэхээс үл хамааран, хувьцаа эзэмшигчдэдээ эрх тэгш хандах зарчмын хүрээнд, тусгайлсан хөнгөлөлт үзүүлэхгүй болно.
3. Боломж бол бий. Гэхдээ олон хүчин зүйлийг харгалзан үзэх нь зүйтэй. Нэгдүгээрт, ногдол ашиг тогтвортой хуваарилахад анхаарах - нэг жилд хэт өндөр дүнтэй хуваарилаад, дараа жил нь огцом бууруулах буюу ногдол ашгийн хэмжээ өндөр



хэлбэлзэлтэй байхыг би хувьдаа зохисгүй гэж үздэг. Хоёрдугаарт, Банкны 2025 оны цэвэр ашгаас хуваарилж буй ногдол ашгийг хувь тэнцүүлбэл, ойролцоогоор цэвэр ашгийн 30 орчим хувийг эзэлж байна. Бидний баримталж буй зорилгын хүрээнд цэвэр ашгийн 1/3-г ногдол ашигт хуваарилах, 1/3-г эрсдэлийн удирдлагад, үлдсэн 1/3-г ирэх жилийн зээлийн өсөлт, бизнесийн хөгжилд хадгалдаг. Иймд ирэх жилүүдэд ногдол ашгийн хэмжээг огцом өсгөх зорилт байхгүй, харин ногдол ашгийг тогтвортой хуваарилах, үйл ажиллагаагаа тогтвортой эрхлэхийг эрмэлзэж байна. Мөн хувьцаа эзэмшигчид маань гагцхүү ногдол ашгаар өгөөж хүртэх бус, хувьцааны үнийн өсөлтөөр өгөөж хүртэж буйг тэмдэглэх нь зүйтэй. Дэлхийн хөрөнгийн зах зээлд ажиглагддаг нэгэн жишээг дурдвал, хэт өндөр дүнгээр ногдол ашиг хуваарилах тохиолдолд хувьцааны ханш эрчимтэй унадаг үзэгдэл бий. Энэ хүрээнд эрсдэлээ удирдаж ногдол ашгийн хэмжээг зохистой түвшинд хадгалдаг.

4. Монголын хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, жижиг хувьцаа эзэмшигчдэд яаралтай үед хувьцаагаа түргэн борлуулах боломжийг бүрдүүлсэн механизмыг бий болгох зорилгоор хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Цаашид мөн энэхүү хөтөлбөрөөр жижиг хувьцаа эзэмшигчдийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэхэд анхаарал хандуулна. Мөн хөтөлбөр нь дэлхий дахинаа хөрөнгийн зах зээлд тусгалаа олсон байдаг бөгөөд эл олон улсын жишгийг бид Монгол Улсын хөрөнгийн зах зээлд нэвтрүүлсэн онцлогтой. Халаасалсан хувьцааг зах зээлд эргүүлэн гаргах цаг хугацааны тухайд, өдгөө халаасны хувьцааны хэмжээ маш бага байгаа учир, хэмжээ мэдэгдэхүйц ихэссэний дараагаар хэрхэх асуудлыг ТУЗ хэлэлцээд, хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлнэ.

ХЭЭХ-д цахимаар оролцож буй өөр нэгэн хувьцаа эзэмшигч тухайн хэлэлцэж буй асуудалд холбогдолгүй асуусан асуултыг Гүйцэтгэх захирал танилцуулав:

1. ТУЗ-ийн бүх хурал цахимаар зохион байгуулагддаг эсэх. Энэ тохиолдолд танхимаар/биетээр зохион байгуулсан хуралтай харьцуулахад үр дүнтэй байж чадах эсэх.

Гүйцэтгэх захирал дээрх асуултад дараах байдлаар хариулав:

1. Банкны ТУЗ нь биетээр/танхимаар жилд 4 удаа буюу улиралд нэг удаа хуралддаг. Ийнхүү ээлжит хурлын дундуур яаралтай шийдвэрлэх асуудал гарах тохиолдолд цахимаар хуралддаг болно. Мөн ТУЗ-ийн гишүүд хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн ирэхийг эрмэлздэгийн хувьд өнөөдөр биечлэн хүрэлцэн ирээд байна. Бид бүх асуудлыг цахимаар шийдвэрлэхийг эрмэлздэггүй бөгөөд уламжлалт арга барил болох биет хуралдаануудыг үргэлжлүүлэн зохион байгуулна. Харин цаг хугацааны хувьд зайлшгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд, цахим хурал хийдэг.

9. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2028 ОНЫ ЭЭЖИЛТ ХУРАЛ ХҮРТЭЛ ХУГАЦААНД БҮРЭН ЭРХ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ

Гүйцэтгэх захирал 2028 оны ХЭЭХ хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийн сонгон шалгаруулалтын талаар танилцуулахаар Гүйцэтгэх ХХЗ/ТУЗНБД-г индэрт урив.

ХХЗ/ТУЗНБД Компанийн тухай хуулийн 77.4 дэх хэсэгт зааснаар хувьцаат компанийн ТУЗ-ийн гишүүдийг санал хураах кумулятив аргаар, бүрэн бүрэлдэхүүнээр нь сонгоно. Мөн Банкны Дүрмийн 8.16 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ-ийн бүрэн эрх 2 жилийн хугацаатай учир 2026 оны ХЭЭХ-аар сонгогдсон ТУЗ нь бүрэн эрхээ 2028 оны ХЭЭХ хүртэл хэрэгжүүлэх талаар тайлбарлаад, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулна уу хэмээн Хурлын даргыг индэрт урив.



Хурлын дарга ТУЗ-д нэр дэвшиж буй нийт нэр дэвшигчдийн дэлгэрэнгүй намтрыг ХЭЭХ-ын материалд оруулсныг дурдаад, нэр дэвшигчдийг дараах байдлаар товч танилцуулав:

“Миний бие ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг эхлэн танилцуулъя.

Нираж Вэдва. Нираж Вэдва нь 2018 оноос хойш ХасБанкны ТУЗ-д ажиллаж байна. Түүний ажлын туршлага нь банк болон санхүүгийн байгууллагын технологийн бүтээгдэхүүний салбарт төвлөрсөн ба банкны салбарын технологийн бүтээгдэхүүн, шийдлүүдийн талаарх хамгийн сүүлийн үеийн мэдлэг, туршлагыг авчрах юм.

Эми Чой. Эми Чой нь сүүлийн гурван жилийн турш ТУЗ-д ажиллаж байна. Тэрээр олон улсын болон бүснугийн банкнуудад ажиллаж байсан ба иргэдийн банкны үйлчилгээний арвин их туршлагыг манай банкинд авчирч байгаа юм.

Стюарт Холл. Стюарт Холл нь сүүлийн хоёр жилийн турш ХасБанкны ТУЗ-д ажиллаж байна. Тэрээр олон банкнуудын Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан туршлагынхаа хүрээнд Монгол улс шиг хөгжиж буй зах зээл дэх банкныг удирдах гүнзгий мэдлэг, туршлагатай нэгэн юм.

Э.Оюунбилэг. Э.Оюунбилэг нь Нэр дэвшүүлэх хорооноос нэр дэвшүүлсэн шинэ нэр дэвшигч юм. Тэрээр компанийн засаглалын сургагч багш бөгөөд хэд хэдэн компаниудад ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж туршлагатай ба засаглалын чиглэлээрх арвин туршлагаа манай банкинд авчрах болно.

Брэд Жонс. Брэд Жонс нь Нэр дэвшүүлэх хорооноос нэр дэвшүүлсэн шинэ нэр дэвшигч юм. Тэрээр төлбөр тооцооны чиглэлээр дагнасан хэд хэдэн компаниудын гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан бөгөөд төлбөр тооцооны салбарт маш арвин туршлагатай нэгэн юм.

Нээлтийн үгэндээ дурдсанчлан, Нэр дэвшүүлэх хорооноос зургаа дахь нэр дэвшигч болох Б.Уламбаярыг анх хараат бус гишүүнээр дахин нэр дэвшүүлсэн байсан ч эцсийн мөчид тэрээр нэрээ татсан юм.

Одоо ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулъя. Энэ ангилал дахь зургаан нэр дэвшигчдийг хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлсэн юм. Харин Цэвэгжав болон миний биеийг Нэр дэвшүүлэх хорооноос нэр дэвшүүлсэн болно.

Майкл Мадден. Майкл Мадден манай ТУЗ-д 17 жилийн турш ажиллаж байна. Тэрээр санхүүгийн компаниудын Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан бөгөөд одоо амжилттай хөрөнгө оруулагч юм. ТУЗ-д хамгийн удаан ажиллаж буй гишүүний хувьд ХасБанк болон Монгол Улсын зах зээлийн талаарх гүн гүнзгий ойлголттой төдийгүй шийдвэр гаргах түвшинд бизнесийн нарийн мэдрэмж, оновчтой сэтгэлгээг авчирна.

Нямтайширын Цэлмүүн. Н.Цэлмүүн нь Монгол Улсын хамгийн том групп компаниудын нэг болох МАК Группийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирлаар ажилладаг. Тэрээр 2012 оноос хойш ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байгаа бөгөөд бизнесийн үйл ажиллагааны арвин туршлага, Монгол улсын талаарх гүн гүнзгий мэдлэгийг авчрах юм.

Гүмэнжавын Цэвэгжав. Манай Банкны Гүйцэтгэх захирлаар 2019 оноос хойш ажиллаж буй Г.Цэвэгжав нь 2011 оноос ХасБанкинд ажиллаж эхэлсэн ба Банкинд удирдах түвшний олон албан тушаал хашиж байсан. 2019 оноос хойш ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байгаа ба Банк болон Монгол улстай холбоотой бүхий л төрлийн асуудлаар гүнзгий мэдлэгтэй нэгэн юм.

Сюзанна Карр. Сюзанна Карр нь 2022 оноос хойш ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна. Тэрээр Америкийн Нэгдсэн Улс дахь Олон Улсын Санхүүгийн Корпорацид олон тооны удирдах албан тушаал хашиж байсан бөгөөд зээлийн багц, зээлийн бодлогын чиглэлээр үнэтэй туршлага авчрах нэгэн юм.



Баатарын Батсайхан. Б.Батсайхан нь дотоодын компанид Гүйцэтгэх захирлын албан тушаалыг хашиж байсан бөгөөд одоо хувийн хөрөнгө оруулалтын чиглэлээр ажиллаж буй хөрөнгө оруулагч юм. Тэрээр үйл ажиллагааны арвин туршлагатайгаас гадна дотоодын асуудал, тулгамдаж буй нөхцөл байдлыг сайн мэддэг. Мөн өмнө нь Тэнгэр Санхүүгийн Нэгдэл болон ХасБанкны ТУЗ-д ажиллаж байсан туршлагатай.

Мелисса Мой Тиен. Мелисса Мой Тиен нь олон улсын хамгийн том банкуудад удирдах албан тушаал хашиж байсан бөгөөд олон улсын банкны салбарын туршлагыг ТУЗ-д авчрах юм. Түүнийг Европын Сэргээн Босголт ба Хөгжлийн Банкнаас нэр дэвшүүлсэн бөгөөд өмнө нь 2019-2021 онд ХасБанкны ТУЗ-ийн гишүүнээр Олон Улсын Санхүүгийн Корпорациас нэр дэвшин ажиллаж байсан туршлагатай.

Ашот Осипян. Ашот Осипян нь шинэ нэр дэвшигч бөгөөд түүнийг Европын Сэргээн Босголт ба Хөгжлийн Банкнаас нэр дэвшүүлсэн. Тэрээр олон банкинд Гүйцэтгэх захирал болон ТУЗ, Хяналтын зөвлөлийн даргын албан тушаал хашиж байсан. Тэрээр хөгжиж буй зах зээлийн банкны салбарын арвин туршлагыг авчрах юм.

Эцэст нь би өөрийгөө танилцуулъя. ТУЗ-д миний авчирч буй давуу тал юу болохыг өөрөө тодорхойлох нь зохимжгүй болов уу. Тиймээс би банкны салбарт ажилласан 45 жилийн карьерынхаа хугацаанд хашиж байсан цөөн хэдэн албан тушаалаа товч дурдаад, дүгнэлтийг та бүхэнд үлдээе. Би ажлын карьерынхаа туршид нийт гурван банкинд ажилласан: Америкийн Банк, Кредит агриколь ба Кредит Лионасс. Эцэст нь ЗӨВ банкаа би 36 жилийн дараа олсон юм. Та бүхэн миний Энэтхэг улс, Европ, Ойрх Дорнод ба Африк болон Ази бүсийг хамруулан хашиж байсан албан тушаалуудтай хурлын материалаас танилцаж болно.

Миний бие тус банкны ТУЗ-д 9 дэх жилдээ ажиллаж байгаа бөгөөд үүнээс сүүлийн 7 жилд нь ТУЗ-ийн даргаар ажиллаж байна.

Би карьерынхаа туршид хөгжингүй болон хөгжиж буй 30 гаруй зах зээлд 45 жилийн турш ажиллаж үзсэнийхээ хувьд ихэнх олон улсын банк эдгээр нэр дэвшигчдийг ТУЗ-дөө ажиллуулахдаа баяртай байх болно гэдгийг итгэлтэйгээр хэлж чадна. Нэг ТУЗ-д ийм эрхмүүдээс 12 нь багтана гэдэг нь үнэхээр бахархмаар хэрэг юм.

Баярлалаа.”

ХХЗ/ТУЗНБД үргэлжлүүлэн, нэр дэвшигчдийн жагсаалтад хараат бус гишүүний 4 орон тоонд нэр дэвшиж буй 5 нэр дэвшигч, ердийн гишүүний 8 орон орон тоонд нэр дэвшиж буй 8 нэр дэвшигч буйг тэмдэглэв.

Хувьцаа эзэмшигчид нь тогтоолоор: (i) шинэ ТУЗ-ийг бүрдүүлэх 12 гишүүнийг сонгох, (ii) одоогийн ТУЗ болон ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсныг хүлээн зөвшөөрөх, мөн (iii) Албертус Браггинкийн албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтийг хүлээн зөвшөөрөх асуудлаар шийдвэр гаргана. ТУЗ-ийн гишүүн Браггинк нь өөрийн хүсэлтээр 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн. ТУЗ нь ТУЗ-ийн гишүүн Албертус Браггинкийн хүсэлтийг хүлээн авч, 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн R-2025-42 дугаар тогтоолоор түүнийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үүрэгт ажлаас нь чөлөөлсөн юм.

Танилцуулгын дараагаар ХХЗ/ТУЗНБД-ын зарласнаар хурлын дэгийн дагуу, хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асууж, хариулт авах цаг эхлэв.

Хувьцаа эзэмшигчид асуулт асуугаагүй тул хэсэг хугацааны дараа хэлэлцэх дараагийн асуудалд оров.

10. ТУЗ-ИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙГ БАТЛАХ ТУХАЙ

ХХЗ/ТУЗНБД ХасБанкны Дүрмийн 8.6(v) дахь заалтад зааснаар ТУЗ-ийн төсөв тогтоох нь хувьцаа эзэмшигчдийн шийдвэрлэх асуудал тул хувьцаа эзэмшигчдийн хурлаар



шийдвэрлүүлэхээр ХасБанкны ТУЗ-өөс 2026 оны төсвийг өмнөх оны адилаар 7 тэрбум 250 сая төгрөгийн дүнтэйгээр оруулсан болохыг тайлбарлав.

ТУЗ-ийн төсөв 2025 онд 7.25 тэрбум төгрөгөөр батлагдаж байсан бөгөөд бодит гүйцэтгэл 6.8 тэрбум төгрөг байсан болохыг тэмдэглэв.

Тэрээр цаашлаад ТУЗ-ийн 2026 оны төсөвт (i) хөлс, нэмэгдэл, урамшуулал, (ii) бусад зардал (татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, зорчих болон буудаллах зардал, ТУЗ-ийн болон хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах зардал, ТУЗ-д хууль зүйн болон бусад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын үйлчилгээний төлбөр зэрэг) багтдаг болохыг дурдав.

Танилцуулгын дараагаар ХХЗ/ТУЗНБД-ын сануулснаар хурлын дэгийн дагуу, хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асууж, хариулт авах цаг эхлэв.

Хувьцаа эзэмшигчид асуулт асуугаагүй тул хэсэг хугацааны дараа хэлэлцэх дараагийн асуудалд оров.

11. САНАЛ ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

Үүний дараа, Хурлын дарга шийдвэрлэх 5 асуудлаар санал хураалтыг эхлүүлэв. Тэрээр дэлгэц дээр эхлүүлсэн 10 минутын хугацаа тоолж дуусмагц бүх санал хураалт нэгэн зэрэг дуусгавар болохыг сануулаад хувьцаа эзэмшигчдийг санал хураалтдаа оролцохыг уриалж тэдгээрийн саналын үнэ цэнтэй болохыг тэмдэглэв.

Саналын хураалтын цаг дуусч санал хураалт хаагдсаны дараа хурлын дэгийн дагуу завсарлага авч, Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгэх ажлыг эхлүүлэв.

12. САНАЛ ХУРААЛТЫН ҮР ДҮН: ШИЙДВЭР

Хурлын даргын урьснаар, Тооллогын комиссын дарга Б.Ананд хувьцаа эзэмшигчдээр батлуулахаар санал болгосон асуудал тус бүрийн санал хураалтын үр дүнг танилцуулав.

Санал хураалт #1: ХасБанкны 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

ХасБанкны 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай асуудлаар санал хураалтын дүнг танилцуулав.

ХасБанкны 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай тогтоолыг батлах эсэх асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид дараах байдлаар санал өгөв:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Хувьцааны тоо	%	Хувьцааны тоо	%	Хувьцааны тоо	%
1,009,682,788	99.8%	0	0%	10	0%

Шийдвэр #1:

ХасБанкны 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай тогтоолын төсөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр, цахим хэлбэрээр болон урьдчилан санал өгч оролцож буй саналын эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн 99.8 хувийн зөвшөөрсөн саналаар батлагдав.

Санал хураалт #2: ХасБанкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай



ХасБанкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай асуудлаар санал хураалтын дүнг танилцуулав.

ХасБанкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай тогтоолыг батлах эсэх асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид дараах байдлаар санал өгөв:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Хувьцааны тоо	%	Хувьцааны тоо	%	Хувьцааны тоо	%
1,009,682,788	99.8%	0	0%	10	0%

Шийдвэр #2:

ХасБанкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай тогтоолын төсөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр, цахим хэлбэрээр болон урьдчилан санал өгч оролцож буй саналын эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн 99.8 хувийн зөвшөөрсөн саналаар батлагдав.

Санал хураалт #3: ХасБанкны 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай

ХасБанкны 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай асуудлаар санал хураалтын дүнг танилцуулав.

ХасБанкны 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай тогтоолыг батлах эсэх асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид дараах байдлаар санал өгөв:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Хувьцааны тоо	%	Хувьцааны тоо	%	Хувьцааны тоо	%
1,009,682,798	99.8%	0	0%	0	0%

Шийдвэр #3:

ХасБанкны 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай тогтоолын төсөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр, цахим хэлбэрээр болон урьдчилан санал өгч оролцож буй саналын эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн 99.8 хувийн зөвшөөрсөн саналаар батлагдав.

Санал хураалт #4: Хувьцаа эзэмшигчдийн 2028 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай

Санал хураалтын дүнг танилцуулахын өмнө, Тооллогын комиссын дарга нь кумулятив аргаар шийдвэрлэх 2028 оны ХЭЭХ хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудлаар нийт саналын тоо 12,598,161,324 (арван хоёр тэрбум таван зуун ерэн найман сая нэг зуун жаран нэгэн мянга гурван зуун хорин дөрөв, саналын эрхтэй хувьцааны тоог ТУЗ-д сонгогдох нийт гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү) ширхэг энгийн хувьцаа байхаар тогтоосныг тэмдэглэв.

Хувьцаа эзэмшигчдийн 2028 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай асуудлаар санал хураалтын дүнг танилцуулав.

Хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид дараах байдлаар ТУЗ-д нэр дэвшигчдэд кумулятив санал өгөв:



#	ТУЗ-д нэр дэвшигчдийн нэр	Дэмжсэн кумулятив саналын тоо
ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчид		
1	Нямтайширын Цэлмүүн	2,401,463,018
2	Санжай Гүпта	1,460,483,861
3	Гүмэнжавын Цэвэгжав	1,453,945,031
4	Сюзанна Карр	1,134,636,697
5	Ашот Осипян	945,624,805
6	Майкл Мадден	851,095,281
7	Мелисса Мой Тиен	845,265,034
8	Баатарын Батсайхан	811,380,975
ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчид		
1	Нираж Вэдва	489,462,140
2	Эрэндоогийн Оюунбилэг	460,993,978
3	Стюарт Доналд Холл	451,905,622
4	Эми Чой (Лай Фунг Чой)	448,219,665
5	Брэд Жонс	356,061,821

Шийдвэр #4:

Хувьцаа эзэмшигчдийн 2028 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдэд дараах нэр дэвшигчид хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр, цахим хэлбэрээр болон урьдчилан санал өгч оролцож буй саналын эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн дэмжсэн саналаар сонгогдов:

ТУЗ-ийн ердийн гишүүнд:

1. Нямтайширын Цэлмүүн;
2. Санжай Гүпта;
3. Гүмэнжавын Цэвэгжав;
4. Сюзанна Карр;
5. Ашот Осипян;
6. Майкл Мадден;
7. Мелисса Мой Тиен; мөн
8. Баатарын Батсайхан.

ТУЗ-ийн хараат бус гишүүнд:

1. Нираж Вэдва;
2. Эрэндоогийн Оюунбилэг;
3. Стюарт Доналд Холл; мөн
4. Эми Чой (Лай Фунг Чой).

Санал хураалт #5: ТУЗ-ийн 2026 оны төсвийг батлах тухай

ХасБанкны ТУЗ-ийн 2026 оны төсвийг батлах тухай асуудлаар санал хураалтын дүнг танилцуулав.

ХасБанкны ТУЗ-ийн 2026 оны төсвийг батлах тухай тогтоолыг батлах эсэх асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид дараах байдлаар санал өгөв:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Хувьцааны тоо	%	Хувьцааны тоо	%	Хувьцааны тоо	%
1,008,490,076	99.7%	0	0%	1,192,722	0.12%

**ХАСБАНК**

ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын тэмдэглэл

Шийдвэр #5:

ХасБанкны ТУЗ-ийн 2026 оны төсвийг батлах тухай тогтоолын төсөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр, цахим хэлбэрээр болон урьдчилан санал өгч оролцож буй саналын эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн 99.7 хувийн зөвшөөрсөн саналаар батлагдав.

Хурлыг хаахаас өмнө Хурлын дарга өнгөрсөн хугацаанд ТУЗ-д гишүүнээр ажилласан Б.Уламбаярт талархал илэрхийлж, дурсгалын зүйлийг гардуулан өгөхөөр Гүйцэтгэх захирлыг урив. Мөн бүрэн эрхийн хугацаа нь дуусч буй бусад 2 гишүүнд мөн дурсгалын зүйл гардуулахаар бэлдсэн боловч тэд хувийн шалтгааны улмаас ХЭЭХ-д хүрэлцэн ирж чадаагүй болохыг дурдав.

ХУРЛЫН ХААЛТ

Хурлын дарга ХЭЭХ-д оролцсон хувьцаа эзэмшигчдэд талархал илэрхийлээд хурлыг албан ёсоор хаав.

Гарын үсэг зурсан:

Санжай Гүпта

Хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлын дарга

Гарын үсэг зурсан:

Н.Мөнхцэлмэг

Хууль хариуцсан захирал бөгөөд
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны
03 дугаар сарын 20-ны өдрийн
R-2026-21 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралт



ЕРДИЙН ЖУРМААР ӨГӨХ САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

Компанийн нэр: ХасБанк ХК

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: _____

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

ХасБанк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 09:00 цагт (Улаанбаатар хотын цагаар) танхим болон цахимаар хосолсон хэлбэрээр зохион байгуулагдана.

Д/д	Шийдвэрлэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	ХасБанкны 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт	☐	☐	☐
2.	ХасБанкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт	☐	☐	☐
3.	ХасБанкны 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах	☐	☐	☐
4.	ТУЗ-ийн 2026 оны төсөв	☐	☐	☐

Хувьцаа эзэмшигчдийн хуралд тавих асуулт болон санал

*Цаг хугацааны бололцоог харгалзан, хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн зарим асуулт, саналыг ээлжит хурлын үеэр танилцуулж, хариулт өгч болно. Ийнхүү хэлэлцэх нь урьдчилан ирүүлсэн саналд гагцхүү хамаарахыг анхаарна уу. Хуралд биечлэн оролцож буй хувьцаа эзэмшигчид нь хурлын үеэр асуултаа шууд тавих боломжтой.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, тайлал: _____ / _____

Бүртгэсэн (үнэт цаасны компани) _____

Саналын хуудсыг хүлээн авсан эрх бүхий этгээдийн гарын үсэг, тайлал: _____ / _____

2026 оны ... сарын ...-ны өдөр

**Тайлбар/Санамж:**

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт (✓) гэж тэмдэглэнэ үү. Таны санал шийдвэрлэх асуудал бүрээр бүртгэлийн өдрөөр эзэмшиж буй хувьцааны тоогоор үржигдэж тооцогдоно.
2. Та саналаа заасан хугацаанд ХасМийтинг аппликейшнээр дамжуулан цахим хэлбэрээр урьдчилан өгөх боломжтой.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн саналаа өгөх бол төлөөлөх хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн итгэмжлэлийг авчран саналын хамт өгсөн тохиолдолд санал хүчинтэйд тооцогдоно.
4. Засварласан, балласан, тэмдэглэгээг буруу үйлдсэн бол санал хүчингүйд тооцогдоно.

Энэ хэсгийг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудасны хүчин төгөлдөр байдал: Хүчинтэй / Хүчингүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, тайлал: _____ / _____

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл, хэрэв бий бол: _____

**КУМУЛЯТИВ АРГААР ӨГӨХ САНАЛ ХУРААЛТЫН ХУУДАС**

Компанийн нэр: ХасБанк ХК

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: _____

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

ХасБанк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 09:00 цагт (Улаанбаатар хотын цагаар) танхим болон цахимаар хосолсон хэлбэрээр зохион байгуулагдана.

Тайлбар/Санамж:

Таны өгөх нийт саналын тоо нь бүртгэлийн өдрөөр таны эзэмшиж буй хувьцааны тоог ТУЗ-ийн нийт гишүүдийн тоо¹ буюу Банкны Дүрмийн дагуу 12-оор үржүүлж тооцогдоно. ТУЗ-ийн 12 гишүүний 8 нь ердийн, 4 нь хараат бус гишүүдээс бүрдэнэ.

Томьёо:	
Саналын эрхийн тоо =	Бүртгэлийн өдрөөр эзэмшиж буй таны хувьцааны тоо x 12

Хувьцаа эзэмшигч нь саналаа ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх боломжтой. Энэхүү арга нь хувьцаа эзэмшигч өөрийн хүсэл зоригор нэг эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид саналаа төвлөрүүлэн өгөх боломжийг олгодог.² Санал хураалтын үр дүнд хамгийн олон санал авсан нэр дэвшигчид нь ТУЗ-ийн гишүүдээр сонгогдоно. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгох саналыг тус тусад нь тоолно. Энэ нь ердийн гишүүнд нэр дэвшигчдийг хооронд нь жагсаан, эрэмбэлэх арга бөгөөд хамгийн олон санал авсан найман нэр дэвшигч ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдоно. Үүний адилаар, хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг мөн хооронд нь жагсаан эрэмбэлж, хамгийн олон санал авсан дөрвөн нэр дэвшигч ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдоно.

Саналаа хуваариалан өгөх жишээ:

Хувьцаа эзэмшигч А нь ХҮ ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Тус компанийн дүрмээр ТУЗ нь 12 гишүүнтэй, үүнээс 4 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоожээ.

¹ Компанийн тухай хуулийн 72.1.3 дахь заалт; СЗХ-ны Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам (СЗХ-2020/09/09 #880)-ын 2.1 дэх хэсэг

² СЗХ-ны Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам (СЗХ-2020/09/09 #880)-ын 3.1 дэх хэсэг



Хувьцаа эзэмшигч А-ийн 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 1200 саналтай болно. Тэрээр дараах байдлаар саналаа хуваарилан өгөх боломжтой:

- Нийт 1200 саналаа бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэр дэвшигчид өгөх; эсхүл
- Нийт 1200 саналын 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 8 хүртэл нэр дэвшигчид, үлдсэн 600 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 4 хүртэл нэр дэвшигчид тус тус өгөх; эсхүл
- Өөрийн нийт саналыг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.

САНУУЛГА: Өөрийн саналыг хэрхэн хуваарилан өгөхөөс үл шалтгаалан, таны өгөх нийт саналын тоо нь дээр дурдсан Томьёоны дагуу тодорхойлсон саналын эрхийн тоотой тэнцүү байх шаардлагатай. Хэрэв таны өгсөн саналын тоо нь таны саналын эрхийн тооноос илүү байх тохиолдолд таны санал хүчингүйд тооцогдохыг анхаарна уу.

№	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Нэр дэвшигчдэд өгөх саналын тоо
ТУЗ-ийн ердийн гишүүнд		
1.	Ашот Осипян	
2.	Баатарын Батсайхан	
3.	Мелисса Мой Тиен	
4.	Майкл Мадден	
5.	Санжай Гүпта	
6.	Сюзанна Карр	
7.	Нямтайширын Цэлмүүн	
8.	Гүмэнжавын Цэвэгжав	
ТУЗ-ийн хараат бус гишүүнд		
1.	Эми Чой (Лай Фунг Чой)	
2.	Брэд Жонс	
3.	Нираж Вадва	
4.	Эрэндоогийн Оюунбилэг	
5.	Стюарт Доналд Холл	

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, тайлал: _____ / _____

Бүртгэсэн (үнэт цаасны компани) _____

Саналын хуудсыг хүлээн авсан эрх бүхий этгээдийн гарын үсэг, тайлал: _____ / _____

2026 оны ... сарын ...-ны өдөр



Тайлбар/Санамж:

1. Та саналаа заасан хугацаанд ХасМийтинг аппликейшнээр дамжуулан цахим хэлбэрээр урьдчилан өгөх боломжтой.
2. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн саналаа өгөх бол төлөөлөх хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн итгэмжлэлийг авчран саналын хамт өгсөн тохиолдолд санал хүчинтэйд тооцогдоно.
3. Засварласан, балласан, тэмдэглэгээг буруу үйлдсэн бол санал хүчингүйд тооцогдоно.

Энэ хэсгийг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудасны хүчин төгөлдөр байдал: Хүчинтэй / Хүчингүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, тайлал: _____ / _____

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл, хэрэв бий бол: _____

